

ТӨВ БАНКНЫ ОВЕРНАИТ РЕПО САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 1, 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх зорилгоор Монголбанкнаас банкинд олгох овернаит репо санхүүжилтийн харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.2.1 “Төв банкны овернаит репо санхүүжилт” гэж банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцэл хийх замаар Монголбанкнаас банкинд “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэл хугацаатай олгож буй санхүүжилтийн байнгын хэрэгслийг хэлнэ.

1.2.2 “Худалдан авах үнэ” гэж худалдан авах өдөр репо хэлцлээр үнэт цаасаа худалдаж буй банкинд Монголбанкнаас төлж буй үнийн дүнг хэлнэ. Худалдан авах үнэ нь тухайн үнэт цаасны зах зээлийн үнээс эрсдэлийн хямдруулалтыг хассан дүн байна.

1.2.3 “Буцаан худалдан авах үнэ” гэж энэ журмын 1.2.2-т заасан худалдан авах үнэ дээр үнийн зөрүүг нэмсэн дүнг хэлнэ.

1.2.4 “Үнийн зөрүү” гэж үнэт цаасыг буцаан худалдан авах үнэ болон худалдан авах үнийн зөрүү бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$\cancel{P_d} = P_p * R_r * \frac{\cancel{d}}{360}$$

$$P_d = P_p * R_r * \frac{d}{365}$$

[Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар өөрчлөв.](#)

P_d - Үнийн зөрүү

P_p - Худалдан авах үнэ

R_r – Овернаит репо хүү (жилийн)

d - Овернаит репо санхүүжилтийн хугацаа

1.2.5 “Купонтой үнэт цаас” гэж хүүгийн тогтмол төлбөр нь үнэт цаасны хугацаа дуустал хоёр талын тохиролцсон хугацааны үе бүрт төлөгддөг үнэт цаасыг хэлнэ.

1.3 Овернаит репо хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны жагсаалтыг Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба (цаашид ЭУА гэх)-наас тодорхойлон гаргаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

1.4 Овернаит репо санхүүжилтийн харилцааг энэ журмаас гадна Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний холбогдох заалтаар зохицуулна.

Хоёр. Овернаит репо санхүүжилтийн нөхцөл

2.1 Овернаит репо санхүүжилтийн хугацаа нь “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэл байна.

2.2 Овернаит репо санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

2.3 Овернаит репо санхүүжилтийн барьцаа нь энэ журмын 1.3-т заасан үнэт цаасны жагсаалтанд орсон үнэт цаас байна.

Гурав. Овернаит репо санхүүжилтийн үндсэн зарчим

3.1 Овернаит репо санхүүжилтийн хэрэгслийг дараах шаардлагыг хангасан банк ашиглаж болно:

~~3.1.1 Монголбанкнаас тогтоох заавал байлгах нооцийн шаардлагыг сүүлийн 3 сарын турш хангаж ажилласан;~~

[МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А-118 дугаар тушаалаар хасав.](#)

3.1.2 Төлбөр тооцооны системд аливаа зөрчил гаргаагүй.

3.2 Монголбанкинд овернаит хадгаламж байршуулсан банкинд Монголбанк овернаит репо санхүүжилт олгохгүй.

3.3 Монголбанкнаас овернаит репо санхүүжилт олгох гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээ, харин буцаан төлөх гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн эхний гүйлгээ байна.

- 3.4 Худалдан авах үнэ, буцаан худалдан авах үнэ нь төгрөг, мөнгөөр илэрхийлэгдэнэ.
- 3.5 ~~Овернайт репо санхүүжилтийн хүү буюу үнийн зөрүүг бодождоо “бодит хуанлийн хоног/360” гэсэн аргачлалыг хэрэглэнэ.~~

[Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар хасав.](#)

- 3.6 Овернайт репо хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны эзэмших эрх шилжих нөхцөл нь эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан байна.
- 3.7 Монголбанк болон банк тухайн үнэт цаасны дугаар, төрөл, тоо ширхэг, жилийн хүүгийн хувь, эзэмших хоногийн тоо, худалдан авах өдөр, буцаан худалдан авах өдөр, худалдан авах үнэ, буцаан худалдан авах үнэ зэргийг тусгасан репо гэрээг репо хэлцэл хийх бүрт Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний хавсралтын дагуу хийнэ.
- 3.8 Гэрээнд заасан худалдан авах өдрийн дараагийн өдөр нь нийтээр амрах баярын өдөр, эсвэл долоо хоногийн амралтын өдрүүд байвал овернайт репо санхүүжилтийн хугацааг үргэлжилсэнд тооцож, хүүг хуанлийн хоногоор тооцно.
- 3.9 Овернайт репо хэлцлийн гэрээний хугацаанд төлөгдөх купоны төлбөрийг худалдагч банк авах эрхтэй. Энэ нь зөвхөн купонтой үнэт цаасанд хамаарна.
- 3.10 Овернайт репо хэлцлээр Монголбанкинд худалдах Төв банкны үнэт цаас (цаашид ТБҮЦ гэх), Засгийн газрын үнэт цаас (цаашид ЗГҮЦ гэх)-наас бусад үнэт цаасны дуусах хугацаа нь буцаан худалдан авах өдрөөс хамгийн багадаа ажлын 3 өдрийн дараа байна.
- 3.11 Монголбанк мөнгөний бодлогын зорилго, чиглэлээс хамаарч тухайн банкинд овернайт репо санхүүжилт олгохоос татгалзаж болно.

Дөрөв. Овернайт репо санхүүжилт олгох үйл ажиллагаа

- 4.1 Энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан банк овернайт репо санхүүжилт авах хүсэлтээ Банк хоорондын цахим арилжааны систем (цаашид БХЦАС гэх)-ээр дамжуулан 17:00-17:10 цагийн хооронд Монголбанкны Валют, эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх)-т ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл албан бичгээр ирүүлнэ.
- 4.2 Монголбанк банкнаас ирүүлсэн овернайт репо санхүүжилтийн хүсэлтийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгална.

4.3 Монголбанк энэ журмын 4.1-д заасан хугацаанаас хойш ирсэн хүсэлтийг хүлээн авахгүй.

4.4 Банкны овернаит репо санхүүжилт авах хүсэлт нь дараах мэдээллийг агуулна:

4.4.1 Овернаит репо санхүүжилт авах огноо;

4.4.2 Банкны нэр;

4.4.3 Овернаит репо санхүүжилтийн хэмжээ;

4.4.4 Банкнийг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг (хүсэлтийг факсаар, эсвэл бичгээр ирүүлэх тохиолдолд).

4.5 Банк овернаит репо санхүүжилт авах хүсэлтийг БХЦАС-д оруулан баталгаажуулсан тохиолдолд цуцлах эрхгүй.

4.6 Монголбанк БХЦАС-д баталгаажсан хүсэлтийг тухайн банкны албан ёсны хүчин төгөлдөр санал гэж үзнэ. Банкнийг төлөөлөн БХЦАС-д нэвтэрч хүсэлт ирүүлэхтэй холбогдон гарч болзошгүй аливаа үйл ажиллагааны эрсдэлийг банк хариуцна.

4.7 Монголбанкны ВЭЗГ банкны хүсэлтийг хянасны үндсэн дээр овернаит репо санхүүжилт олгох шийдвэрийг БХЦАС-ээр дамжуулан Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т 17:15 цагаас өмнө хүргүүлнэ.

4.8 Монголбанкны ВЭЗГ “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний хавсралтын дагуу банктай овернаит репо санхүүжилтийн гэрээ байгуулж, гэрээний нэг хувийг Монголбанкны ТТБГ-т хүргүүлнэ.

4.9 Монголбанкны ТТБГ овернаит репо санхүүжилтийг банкны харилцах дансанд тухайн банкны тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээгээр шилжүүлж, холбогдох нягтлан бодох бүртгэлийг хийнэ.

4.10 Монголбанкны ТТБГ овернаит репо санхүүжилтийг хүүгийн хамт дараагийн ажлын өдөр “Банксүлжээ” систем нээгдэхэд банкны харилцах данснаас суутган төлүүлнэ.

Тав. Өдрийн зээлийг овернаит репо санхүүжилтэнд шилжүүлэх

5.1 Өдрийн репо хэлцлээр авсан зээлийг овернаит репо санхүүжилтэнд шилжүүлэх банкны хүсэлтийг үндэслэн өдрийн зээлийг овернаит репо санхүүжилтэнд шилжүүлнэ.

5.2 Энэ журмын 5.1-д заасны дагуу овернаит репо санхүүжилтэнд шилжүүлэх зээлийн дүн нь тухайн банкны төлөөгүй өдрийн зээлийн үлдэгдэлтэй тэнцүү байна.

5.3 Өдрийн зээлээс овернаит репо санхүүжилтэнд шилжүүлсэн зээлийн харилцаа нь энэ журмын бүхий л заалтыг дагаж мөрдөнө.

Зургаа. Овернаит репо санхүүжилтийн бүртгэл

6.1 Төв банкны овернаит репо санхүүжилтийн нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан, хүчин төгөлдөр мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хийнэ.

6.2 Гэрээнд заасан худалдан авах өдөр Монголбанк худалдагч банкны дансанд худалдан авах үнийн дүнг шилжүүлэх, худалдагч банк эзэмшиж буй үнэт цаасаа Монголбанкинд шилжүүлэх гүйлгээ нэгэн зэрэг хийгдэнэ. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд репо хэлцэл хийсэн өдөрт багтаан хийнэ.

6.3 Гэрээнд заасан буцаан худалдан авах өдөр худалдагч банк буцаан худалдан авах үнийг, Монголбанк үнэт цаасыг буцаан шилжүүлэх гүйлгээ нэгэн зэрэг хийгдсэнээр репо хэлцэл дуусгавар болно. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах өдөрт багтаан хийнэ.

6.4 Репо хэлцлээр хүлээсэн үүргийг аль нэг тал биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний 5.2-т заасан хариуцлагын арга хэмжээг авна.

6.5 Монголбанкны ТТБГ овернаит репо санхүүжилтийн үлдэгдлийг өдөр бүрийн банкуудтай хийх өглөг, авлагын тайланд тусгана.

Долоо. Бусад

7.1 Энэ журмын заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2 Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.